



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 112

Улаанбаатар хот

Барилга байгууламжийг нийслэлийн
өмчид бүртгэн авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Баянгол, Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан 7,389,704,416.00 (долоон тэрбум гурван зуун наян есөн сая долоон зуун дөрвөн мянга дөрвөн зуун арван зургаа) төгрөгийн өртөг бүхий нэгдүгээр хавсралтад дурдсан, Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр баригдаж, ашиглалтад орсон 2,026,119,347.00 (хоёр тэрбум хорин зургаан сая нэг зуун арван есөн мянга гурван зуун дөчин долоо) төгрөгийн өртөг бүхий хоёрдугаар хавсралтад дурдсан, нийт 9,415,823,763.00 (есөн тэрбум дөрвөн зуун арван таван сая найман зуун хорин гурван мянга долоон зуун жаран гурав) төгрөгийн өртөг бүхий 5 барилга байгууламжийг нийслэлийн өмчид бүртгэн авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д зөвшөөрсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-нд даалгасугай.


ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1110101101


Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн
112 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖУУДЫН ЖАГСААЛТ

Д/д	Барилга байгууламжийн нэр	Байршил	Барилга байгууламж ашиглалтад орсон огноо	Төсвийн хөрөнгөөр худалдан авсан огноо	Бүртгэх үнэ /төгрөгөөр/	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр
1	Баянгол дүүргийн 25, 28 дугаар хорооны цогцолбор барилга	Баянгол дүүргийн 25 дугаар хороо, Үйлдвэрийн бүс /16010/ Энхтайваны өргөн чөлөө гудамж, 43/4 тоот	2014.03.25	2024.04.26	4,189,704,416.00	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт
2	267 дугаар цэцэрлэгийн Б барилга	Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороо, Консулын 20 дугаар гудамж, 545-А тоот, Өгөөмөр захын хойд талд	2006.12.01	2023.06.15	1,600,000,000.00	
3	319 дүгээр цэцэрлэгийн Б барилга	Баянзүрх дүүргийн 40 дүгээр хороо, Да хүрээ гудамжны 65/1 тоот, Грийн апартамент хотхоны урд талд	2016.04.20	2023.12.01	1,600,000,000.00	
НИЙТ ДҮН					7,389,704,416.00	

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн
112 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖУУДЫН ЖАГСААЛТ

Д/д	Барилга байгууламжийн нэр	Байршил	Барилга байгууламж ашиглалтад орсон огноо	Бүртгэх үнэ /төгрөгөөр/	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр
1	188 дугаар цэцэрлэгийн барилга	Сонгинохайрхан дүүргийн 33 дугаар хороо, Тахилтын задгай, 122 дугаар сургуулийн хажуу талд	2023.12.18	1,040,726,183.00	Нийслэлийн үнэт цаасны хөрөнгө
2	271 дүгээр цэцэрлэгийн барилга	Сонгинохайрхан дүүргийн 33 дугаар хороо, Давхрын буудал, 10 дугаар гудамж	2023.12.18	985,393,164.00	
	НИЙТ ДҮН			2,026,119,347.00	